



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/50

Мандалговь

Төрийн архивын баримтад нэгдсэн тооллого
зохион байгуулах тухай

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, 17 дугаар зүйлийн 17.1.7, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/204 дүгээр тушаалаар баталсан “Төрийн архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 6.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архивын баримтын нэгдсэн тооллогыг 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Архивын хадгаламжийн санд хадгалагдаж буй баримтад нэгдсэн тооллого явуулах ажлын хэсгийн дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Т.Уранбайгаль (Архивын тасгийн дарга)

Гишүүдэд: Б.Хандмаа (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Ө.Дэнсмаа (Цахимжуулалт хариуцсан ажилтан)

Х.Дашням (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Д.Даариймаа (Хяналт - шинжилгээ, үнэлгээний
хэлтсийн мэргэжилтэн)

Г.Жавзмаа (Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Ч.Оюунсайхан (Архивч, сан хөмрөгийн эрхлэгч)

3. Нэгдсэн тооллого хийх ажлыг зохион байгуулж, дүн мэдээг тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч (Т.Уранбайгаль)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДОРЖБАТ



4820150110